



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/021/НА-СТА-ТТЗ**

Чингис хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Баярбаатар  
Утас: 99058696 Цахим хаяг: bayarbaatarkha@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

Асуудлыг онцолсон хэсэг.....	2
Аудитын гол асуудал .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>6</b>
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>13</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....</b>	<b>15</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 527  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын 70,021.2 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 58,339.1 мянган төгрөг нийт 128,360.3 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

**Засаг дарга нь:** Зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр орон нутгийн ерөнхий орлого, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сангуудын урьд оны үлдэгдлийг дутуу төлөвлөсөн. Хоршоо хөгжүүлэх сангийн 5-аас дээш жил хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн зээлийг төлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**Засаг даргын тамгын газар нь:** Тайлант хугацаанд ажлын үр дүнгээр урамшуулал давхардуулан олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан. Нутгийн удирдлагын ордны барилгын зураг төслийн тайланд өглөгөөр тусгаагүй төлбөрийг төлсөн. Усны төлбөр нэрээр үйлчлэгчийн дансанд мөнгө шилжүүлсэн. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актын төлбөрийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төлсөн.

Санхүүгийн албаны даргын сул орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд Засаг даргын тамгын газрын нягтлан бодогчид түр хавсран гүйцэтгүүлж үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдэл олгосон. Засаг даргаар ажиллаж байсан иргэнд нэг удаагийн тэтгэмжийг илүү олгосон. Сумын онцгой комиссын шийдвэргүйгээр үнэ бүхий нөөц тэжээлийг зарлагдаж, борлуулалтын орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд олон нийтэд мэдээлэхгүй, Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлэлгүйгээр шаардлага хангаагүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлж байна. Энэ нь:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна"
- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:", 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.", 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.", 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна."
- ✓ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.",
- ✓ 16 дугаар зүйлийн 16.5.2. "төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын

гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах

- ✓ Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-43.5."Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна." 43.5."Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална".
- ✓ Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ." гэснийг зөрчсөн байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны төсвийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн төсвийн орлогоос 382,275.6 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс 1,516,512.6 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгээс 269,448.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 774,284.6 мянган төгрөг нийт 2,957,520.8 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталжээ.

Төсвийн тодотголоор аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 246,900.6 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг 85,354.2 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвийн орлогыг 48,964.4 мянган төгрөгөөр, урьд үлдэгдлийг 138,251.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,812,481.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн авч 2,026,442.3 мянган төгрөгийг зарцуулж, 481,389.8 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 586,426.3 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илрүүлснээс 54,329.0 мянган төгрөгийн 5 алдааг санхүүгийн тайланд аудитын явцад залруулж, 519,004.1 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 13,093.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосон.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд нийт 72,174.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,153.4 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 38,432.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 31,588.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч ажиллалаа.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Баянмөнх сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 23 дугаар хуралдаанаар Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай дүгнэж тайланг “Үр дүн гарсан” гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан****/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,328,566.32	1,357,227.98
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	951,164.29	953,273.69
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	88,507.74	71,479.55
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	300.00	70,300.00
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	265,074.30	238,674.75
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	23,520.00	23,500.00
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,134,625.50	3,020,092.21
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,134,625.50	3,020,092.21
9	1.2.2.02 Биет хөрөнгө		3,097,489.50	2,982,956.21
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	37,136.00	37,136.00
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		4,463,191.82	4,377,320.19
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.00	99,191.00
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.00	99,191.00
14	2.1.1.03 Өглөг		0.00	99,191.00
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,463,191.82	4,278,129.19
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		4,463,191.82	4,278,129.19
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		463,938.49	463,938.49
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		3,925,202.59	3,740,139.96
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		74,050.74	74,050.74
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		4,463,191.82	4,377,320.19

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,500,648.02	2,242,370.02
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		662,814.92	501,023.38
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		350,119.87	337,386.63
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		350,119.87	337,386.63
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		45,760.51	25,461.70
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		266,934.54	138,175.05
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	445,114.72	1,741,346.65
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.00	1,286,763.00
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО		1,392,718.39	0.00
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,786,567.47	2,427,425.66
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,786,567.47	2,209,401.72
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,732,324.13	2,187,683.16
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		597,736.52	834,997.01
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		75,339.64	104,889.00
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		103,225.08	387,522.73
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		89,338.64	93,499.87
17	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		46,157.97	55,184.10
18	1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		27,954.00	26,680.00
19	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		367,056.16	159,302.30
20	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		425,516.12	525,608.16
21	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		54,243.34	21,718.56
22	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.00	218,023.93
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		714,080.55	-185,055.64
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		219,090.79	0.00
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-219,090.79	0.00
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		494,989.76	-185,055.64

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**
**/мянган төгрөгөөр/**

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,133,327.76	1,996,227.39
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	662,814.92	501,023.38
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	350,119.87	337,386.63
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	45,760.51	25,461.70
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	266,934.54	138,175.05
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	36,335.39	30,165.62
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,445.75	1,710.33
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	229,153.40	106,299.10
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,794.45	1,495,204.01
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	77,794.45	24,347.21
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.00	1,286,763.00
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	184,093.80
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,392,718.39	0.00
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,511,792.65	1,732,524.19
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,511,792.65	1,732,524.19
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,457,549.31	1,706,405.49
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,736.88	834,224.31
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,339.28	104,889.00
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	367,534.64	387,390.73
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	50,877.69	40,636.34
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	2,800.00	2,637.00
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	56,693.17	67,536.80
23	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	28,044.00	25,980.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	118,439.45	178,655.95
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	160,084.20	64,455.36
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,243.34	26,118.69
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	621,535.11	263,703.20
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	178,403.22	261,593.80
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	178,403.22	261,593.80
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	178,403.22	261,593.80
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-178,403.22	-261,593.80
32	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	443,131.89	2,109.40
33	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	508,032.40	951,164.29
34	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	951,164.29	953,273.69

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,925,385.99		3,925,385.99
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	42,816.07		42,816.07
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,968,202.06		3,968,202.06
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	494,989.76		494,989.76
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,463,191.82		4,463,191.82
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,463,191.82		4,463,191.82
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-7.00		-7.00
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,463,184.82		4,463,184.82
9	1.7 Тайлант үеийн үр дүн	-185,055.64		-185,055.64
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,278,129.19		4,278,129.19

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,899,945.90	1,977,606.48
2	3.1.01.1.1 Татварын орлого	422,240.00	501,023.38
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	335,260.00	337,386.63
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	335,260.00	337,386.63
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	270,000.00	273,150.51
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	40,000.00	42,572.10
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	24,000.00	20,341.31
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,260.00	1,322.70
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	7,000.00	25,461.70
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	5,500.00	3,819.50
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	1,500.00	690.00
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	0.00	20,952.20
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	79,980.00	138,175.05
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	26,500.00	30,165.62
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	12,500.00	15,359.02
16	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	14,000.00	14,806.60
17	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	2,000.00	1,710.33
18	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	2,000.00	1,710.33
19	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	51,480.00	106,299.10
20	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	51,480.00	106,299.10
21	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,477,705.90	1,476,583.11
22	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	24,000.00	22,877.21
23	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	8,000.00	6,909.00
24	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	15,000.00	15,968.21
25	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.00	0.00
26	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,269,612.10	1,269,612.10
27	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,269,612.10	1,269,612.10
28	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	184,093.80	184,093.80
29	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	184,093.80	184,093.80
30	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,812,481.90	2,547,274.08
31	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,195,336.10	2,285,680.28
32	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,155,147.40	1,692,477.82
33	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	881,044.40	833,709.81
34	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	386,684.40	372,310.04
35	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	404,396.00	397,452.51
36	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	36,960.00	43,862.97
37	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	17,490.00	12,096.30

38	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	35,514.00	7,988.00
39	3.1.01.2.1.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,852.00	104,129.84
40	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	75,379.40	70,952.23
41	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	8,868.10	8,187.43
42	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,434.10	4,370.05
43	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,434.10	4,062.69
44	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	17,736.30	16,557.43
45	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	643,763.30	387,390.73
46	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	176,680.70	46,892.89
47	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	419,542.50	308,799.84
48	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	47,540.10	31,698.00
49	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	58,566.80	38,044.94
50	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	9,910.50	6,275.50
51	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	36,994.40	25,612.16
52	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,588.60	3,480.28
53	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	518.40	0.00
54	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,554.90	2,677.00
55	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	4,807.10	2,637.00
56	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807.10	2,637.00
57	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	70,691.50	64,536.80
58	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	11,748.40	10,827.70
59	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,943.10	0.00
60	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	57,000.00	53,709.10
61	3.1.01.2.1.1.7 Томилот, зочны зардал	40,617.40	25,980.00
62	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	40,617.40	25,980.00
63	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	260,078.00	172,200.35
64	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	254,561.10	169,381.12
65	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	0.00
66	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	1,014.30	1,014.30
67	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	536.40	444.20
68	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	188.00
69	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,795.40	1,050.00
70	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	963.50	122.72
71	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	84,726.90	63,848.36
72	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	74,490.50	59,638.36
73	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,236.40	4,210.00
74	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,188.70	593,202.46
75	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	571,784.00
76	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	0.00	571,784.00
77	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	40,188.70	21,418.46

78	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,642.20	13,642.20
79	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,546.50	7,776.26
80	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	360,845.80	261,593.80
81	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	360,845.80	261,593.80
82	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	256,300.00	0.00
83	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	256,300.00	0.00
84	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-912,536.00	-569,667.60
85	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	912,536.00	569,667.60
86	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	912,536.00	569,667.60
87	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	950,968.59
88	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	953,084.99

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Аудитлагдсан дүн
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	17,150,902.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,150,902.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	17,150,902.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	17,150,902.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	17,150,902.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,491,015.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,659,887.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,700,673.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	12,700,673.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,700,673.00
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	514,500.00
210104	1.1.1.2.1.1.1.4 Урамшуулал	514,500.00
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	759,168.00
210201	1.1.1.2.1.1.2.1 Тэтгэврийн даатгал	759,168.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	2,591,405.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	2,591,405.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00
210601	1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл	1,900,000.00
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	1,100,000.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,235,600.00
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,235,600.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	4,450,229.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(4,450,229.00)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(4,450,229.00)

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Баянмөнх сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа орон нутгийн төсвийн 2, улсын төсвийн 4 байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС, ЭМТ-ийн санхүүгийн тайланд Ари файнэнс аудит ХХК аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн.

Сумын ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Соёлын төв аудитын түүвэрт хамрагдсан болно.

**3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 586,426.3 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс 54,329.0 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 519,004.1 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 13,093.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:**

#### Аудитын илрүүлэлт:

##### **Засаг даргын тамгын газар**

1. Нутгийн удирдлагын ордны барилгын зураг төслийг 2020 онд Анга транс ХХК-р хийлгэж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, 2024 оны 9 сарын 11-ний өдрийн Шүүхийн шийдвэрээр 27.7 сая төгрөгийг төлсөн.

2. Ус ашиглалтын гэрээгүй, усны хэрэглээний тайлан, анхан шатны баримтын шаардлага хангахгүй баримтаар усны төлбөр 9.8 сая төгрөгийг үйлчлэгчийн данс руу, Алаг адуут буян ХХК-ийн дансанд 4.2 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн.

3. ЗДТГ-ын албан хаагчдад 2022-2023 онд олгосон түлээ нүүрсний хөнгөлөлт, мал тооллогын судалгаа, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болох хөдөлмөрийн хөлсөнд ногдох шимтгэл, алдангийг нөхөн төлүүлэх 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 23 тоот Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актын төлбөрийг өглөг үүсгэлгүйгээр нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төлсөн.

4. Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 12 -ны өдрийн Б/35 тоот тушаалаар Санхүүгийн албаны даргын сул орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд Засаг даргын тамгын газрын нягтлан бодогчид түр хавсран гүйцэтгүүлж үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдэл олгосон.

5. Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд олон нийтэд мэдээлээгүй, Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлэлгүй Засаг даргын тамгын газрын дарга, Төрийн сангийн мэргэжилтэн, Санхүүгийн албаны дарга, Хоршоо, хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нарын албан үүргийг шаардлага хангаагүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлж байна.

##### Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 3 албан шаардлага хүргүүлсэн.

1. Тайлант хугацаанд ажлын үр дүнгээр урамшуулал авсан боловч балансын үр дүнгийн урамшуулал нэрээр 2 албан хаагчид 5.3 сая төгрөгийг давхардуулан олгосон.

2. Засаг даргаар ажиллаж байсан иргэнд олгох нэг удаагийн тэтгэмжийг 772.2 мянган төгрөгөөр илүү олгосон.

3. Сумын онцгой комиссын шийдвэргүйгээр 178 шуудай 4,094.0 мянган төгрөгийн үнэ бүхий тэжээл, 100 шуудай 2,900.0 мянган төгрөгийн үнэ бүхий хүчит тэжээл нийт 6,994.0 мянган төгрөгийн нөөц тэжээлийг зарлагдаж, борлуулалтын орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөр барагдуулах 3 акт тогтоосон.

3.1.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийцлийн аудитын асуудлаар хүргүүлсэн 2 албан шаардлагыг энэ тайлангийн 4.4.1-т тусгасан болно.

**3.2. Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 122,618.3 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 74,878.2 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 47,433.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 306.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:**

Аудитын илрүүлэлт:

#### **Ерөнхий боловсролын сургууль**

1. Өглөгийн эхний үлдэгдлийг 3,000.0 мянган төгрөгөөр бууруулж өөрчилсөн. Мөн тайлант оны санхүүгийн тайланг зэрэгцүүлсэн байдлаар гаргаж тайлагнаагүй.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан 43,667.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тооллого хийж, тооцоо бодож баталгаажуулаагүй.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлсэн.

#### **Цэцэрлэг**

1. Баянмөнх сумын Ерөнхий боловсролын сургуульд үндсэн орон тоонд ажилладаг, хүүхдийн цэцэрлэгт нягтлан бодогчийн албан үүргийг хавсран ажиллаж, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалгүйгээр хоёр байгууллагаас ээлжийн амралтын цалинг давхардуулан авсан.

Шийдвэрлэлт: Зөрчлийг таслан зогсоох 1 төлбөрийн акт тогтоосон.

#### **Эрүүл мэндийн төв**

8. Тайлант онд 2 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүй 306.720 төгрөгийн цалин давхардуулан олгосон.

Шийдвэрлэлт: Илүү олгосон цалинг төлүүлэх 1 төлбөрийн акт хүргүүлсэн.

3.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийцлийн аудитын асуудлаар хүргүүлсэн 1 албан шаардлагыг энэ тайлангийн 4.3-т тусгасан болно.

**3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 70,021.2 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 2,153.4 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 38,432.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 31,588.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.**

#### **3.3.1 Алдаа**

1. Замд яваа мөнгөн хөрөнгө 2,153.4 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг санхүүгийн тайланд залруулав.

### 3.3.2 Албан шаардлага:

1. Орон нутгийн ерөнхий орлогын дансны урьд оны үлдэгдлээс 2,879.1 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс 35.547.0 мянган төгрөгийг, Хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс 6.5 мянган төгрөг нийт 38,432.5 мянган төгрөгийг дутуу төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

### 3.3.3 Зөвлөмж

1. Хоршоо хөгжүүлэх сангийн 5-аас дээш жил хугацаа хэтэрсэн 15 зээлдэгчийн 31.6 сая төгрөгийн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хоршоо хөгжүүлэх сангийн 5-аас дээш жил хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээ авч тодорхой үр дүнд хүрсэн байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	1	2,156.9	1	2,156.9			1	2,156.9				
ЗДТГ	2	26,041.8			2	26,041.75	2	26,041.8				
ХХС	2	26,130.3	1	20,952.2	1	5,178.1	2	26,130.3				
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>5</b>	<b>54,329.0</b>	<b>2</b>	<b>23,109.1</b>	<b>3</b>	<b>31,219.9</b>	<b>5</b>	<b>54,329.0</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>0</b>	<b>0.00</b>
ЕБС	1	74,671.3			1	74,671.3	1	74,671.3				
Цэцэрлэг	2	206.9			2	206.9	2	206.9				
<b>УТБ-ын дүн</b>	<b>3</b>	<b>74,878.2</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>3</b>	<b>74,878.2</b>	<b>3</b>	<b>74,878.2</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>0</b>	<b>0.00</b>
Засаг дарга	1	2,153.4	1	2,153.4			1	2,153.4				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>1</b>	<b>2,153.4</b>	<b>1</b>	<b>2,153.4</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>1</b>	<b>2,153.4</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>0</b>	<b>0.00</b>
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>131,360.5</b>	<b>3</b>	<b>25,262.5</b>	<b>6</b>	<b>106,098.0</b>	<b>9</b>	<b>131,360.5</b>	<b>0</b>	<b>0.00</b>	<b>0</b>	<b>0.00</b>

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	6	58,339.1	3	13,093.2	3	45,245.9						
<b>ОНБ-ын дүн</b>	<b>6</b>	<b>58,339.1</b>	<b>3</b>	<b>13,093.2</b>	<b>3</b>	<b>45,245.9</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
ЕБС	2	43,667.4			2	43,667.4						
Цэцэрлэг	1	1,390.0	1	1,390.0								
ЭМТ	1	306.7	1	306.7								
<b>УТБ-ын дүн</b>	<b>4</b>	<b>45,364.1</b>	<b>2</b>	<b>1,696.7</b>	<b>2</b>	<b>43,667.4</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
Засаг дарга	2	70,021.2			1	38,432.5	1	31,588.7				
<b>ТТЗ-ийн дүн</b>	<b>2</b>	<b>70,021.2</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>1</b>	<b>38,432.5</b>	<b>1</b>	<b>31,588.7</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>173,724.4</b>	<b>5</b>	<b>14,789.9</b>	<b>6</b>	<b>127,345.8</b>	<b>1</b>	<b>31,588.7</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
ИТХ	1	190,912.4			1	190,912.4						
ХХС	1	282,845.8			1	282,845.8						
<b>ОНТБ-ын дүн</b>	<b>2</b>	<b>473,758.2</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>473,758.2</b>	<b>0</b>	<b>-</b>				
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
ЭМТ	1	2,376.0			1	2,376.0						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,376.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>2,376.0</b>	<b>0</b>	<b>0</b>				
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>476,134.2</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>476,134.2</b>	<b>0</b>	<b>-</b>				



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 282-А2370456

Чингис хот

ХЭА-2026/021/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн сангийн ерөнхий орлогын 2,879,071.58 (хоёр сая найман зуун далан есөн мянга далан төгрөг тавин найман мөнгө) төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 35,546,968.96 (гучин таван сая таван зуун дөчин зургаан мянга есөн зуун жаран найман төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 6,464.85 (зургаан мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг наян таван мөнгө) төгрөг, нийт 38,432,504.39 (гучин найман сая дөрвөн зуун гучин хоёр мянга таван зуун дөрвөн төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн урьд оны үлдэгдлийг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тусган төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг арилган биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга О.Нямдаваад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Х.БАЯРБААТАР